

1910-1930-ААД ОНЫ МОНГОЛЫН НОМ, ХЭВЛЭЛД СОЛОНГОСЫН ТУХАЙ МЭДЭЭЛЖ БАЙСАН НЬ

Ж.Баттөр
МУИС-ийн ОУХНУС
Профессор, Доктор (Ph.D)

Солонгос улс, Солонгосын ард түмний талаарх тэр үеийн Монгол улсын Засгийн газрын байр суурийг тодорхойлон гаргаж, задлан шинжлэхэд тухайн цаг үед хэвлэгдэж байсан Монголын тогтмол хэвлэл, сурах бичиг, дотоод, гадаадын эрдэмтдийн бичиж байсан өгүүлэл чухал ач холбогдолтой юм. 1920-аад оноос Монголын хэвлэлд Солонгосын тухай бичих, нийтлэх нь улам бүр ихэссэн гэж хэлж болно. Ингэхдээ ихэвчлэн Японы колончлолын дарлалд зовж буй Солонгосын ард түмний хүнд хүчир амьдрал, тэдний тэмцлийг ард олонд танилцуулах, мэдээлэх, сэтгэл санааны хувьд дэмжих зорилгоор ийнхүү хэвлэн нийтэлж, олонд түгээх зорилгыг эн тэргүүнд тавьж байсан юм. Тухайлбал тэртээх 1910-аад оны монгол хэвлэлүүдээс иш татан сонордуулахул: “Улсаа сөнөөгдсөн Гууль улсын сонсгол... Хараахан Гууль (хятадаар Солонгосыг “Гаоли” гэдэг. Энэ үгийг монголжуулж Гууль улс гэжээ. Ж. Б) улсыг И-пэнь (Японыг хятадаар “Рибэнь” гэдэг. Энэ үгийг монголжуулж И Пэнь гэжээ. Ж.Б)-ий харьяат эзэрхэг эрхэнд орсоноос хойшид Баруун олон улсын сонин дээр Гууль улсын байдлыг тодорхойлон бичсэнгүй ажээ. Эдүгээ гадаад улсын сонин дээр Гууль улсын байдлыг хураангуйлан бичсэн нь ийн. Гууль улсыг Япон хүмүүн өөрийн боол шивэгчин болгож, бүх Гуулийг Ерөнхийлөн захирах тэргүүн зэргийн цондуу суулгажээ. Улсаа сөнөөлгөсөн аймаг хөөрхийлөлтэй хэмээсэнд эл учрыг И-пэний нэгэн эмч хүмүүн өөрийн сонин дээр шүүмжлэн: Гууль улс И-пэний харьяат болсноос хойш түүний байдал улам сайжирч чадсан боловч Гуулийн хүмүүн ард И-пэнь улсад үнэн сэтгэлийн үг хэлэх үгүй цээжний дотор өшөө хадгалмой.

Аливаа шүүх таслах хэрэг дор И-пэнь, Гууль нарыг цөм нэгэн адил чанарт хуулийн ёсоор шийтгэхээс бус өчүүхэн татаж түлхэх үгүй аж. Тийн бөгөөтөл Гууль хүмүүн нар И-пэнд хийж албан суух өөрийн харьяат хүмүүн нарыг урвасан тагнуулчин хэмээн жигшмой. Тиймийн тул И-пэн хүмүүн бас үнэн сэтгэлээр Гуулийг итгэмжлэх үгүй байдаг учир нь энэ болой. Үүнээс хойш И-пэн улсын сайд ноёд Гуулийн бүх хүмүүний сэтгэлийг өөртөө татан оруулж эс чадах бөгөөс үүрд өөрийн нэгэн албат хэмээн итгэмжлэх нь бэрх ажгуу. Эмч би шударгыг барьж шүүмжилвээс Гууль хүмүүний манай И-пэнд үл бишрэх нь маш зөв бололтой. Жишээлхүй дор баахан нялхадын хүзүүнээ дээс оруулж

татвал эрхбиш уурсаж гомдох болой. Түүнчлэн Гууль хүмүүс өөрийн дотоод эрхээ И-пэнд булаагдаж эрхээн эзэрхэн чадсан үгүй болсон тул И-пэнд яахан үнэн зүрхнээс итгэмжлэх билээ. Эртдээ Гууль хүмүүн эрдэм чадал мөхөс байсан боловч өөрөө эзэрхэх эрхтэй багахан улс байжээ. Тийнхүү одоо И-пэний эрх дор ороод догшин ширүүн зантай И-пэн сайд, ноёдын дарлахыг хүлээн зовж хэмээн өгүүлжээ. (“Монголын сонин бичиг”, 1912 оны дугаараас)

“Япон улсын Засгийн газраас Солонгос өмнөд, умард Манж газрыг эзлэн аваад яаралгүйгээр Дундад улсын бусад муж, жич Оросын алс Дорно зүг дэх Приморск зэрэг газарт Жан Зүо Лин лугаа хуйвалдан нэлээд түйвээн чадах хүч нэмэгдэв хэмээмүй. Японы Токио, Осака, Асаки хотын олон сэтгүүлд өгүүлсэн нь улсын ашиг хязгаарыг ихэтгэхийн тул Оросын цагаан намд тусласан ба цэрэг зэвсэг хөдөлгөж Оросын дотоод хэрэгт оролцсон учир Японы ардын 600 сая жан хилс сүйтгэгдсэнээс гадна алс Дорнод зовхист урьдын нэвтрүүлэн агсан аливаа худалдаа арилжаа бөглөгдөн зогссон ба Орос, Японы хоорондын найрамдал эвдэрч харилцан өшөөтөн болжээ. Тэр ч байтугай Японы Владивосток хотноо бүхүй колонын ард жич Приморск хязгаарт бүхүй цэргийг татаж авах ба Зөвлөлийн Засагт Орос улс лугаа найрамдахыг эрмэлзмүй хэмээжээ. (Японы сонин)

Хан Хэү хотноо Дундад улсын хэмжээт Ү Чин газар суух Солонгосын иргэний лам Лий овогтыг Японы цагдаа цэргээс хувьсгалын хэрэгт барнулан авч гянданд хорьсон бөгөөд, огт Дундад улсын албаны газар мэдэгдээгүй гагцхүү түүний зориг мэдлээр аваачсаныг олон анги хурлын газраас зөвшөөн хүлээхгүй татгалзаж бичиг өгөв хэмээмүй. (“Хураангуй сэтгүүл”-ийн 10-р хуудас)

Японы зэвсгийн хашаа галдагдсан учир

Бээжингийн Ии Ши Бу хэмээх сонинд гарсан нь:

Япон улс дор газар хөдлөхүй дор олон бүхний хүмүүс амь биеэ гарахыг бодож яаран сандрахуй дор Гууль улсын хүмүүс түүний зэвсгийн хашаан дор гал талбижихуй хэмээмой. Гууль улсын хүмүүс гадаад улсаас сүрэг сүргээр уул улсдаан буцаж аху ану:

Бээжингийн Ии Ши Бу хэмээх сонин дор гарсан ану, Гууль улсын хүмүүс Японы дарлалыг тун хүлээн чадах үгүй тул гадаад улс дор амь биеэ хамгаалахаар зайлан явсан нь олон буй бөлгөө. Эдүгээ Японы их аюулыг сонсоод өөрийн улсын тулгарыг дахин мандуулах сайн цаг хэмээн гадаад улсаас сүрэг сүргээр уул улсдаан буцаж буй хэмээмой. Япон улс дор газар хөдөлж, үүнээс урьд гарсан гол усны аюулаас амьдаар гарсан ард ба ажлын үйлдвэрчдийн идэх хоол хүнс зэргийн юмаар маш дутагдан гачигдаж буй тул эдүгээ журамт ардын

үзэлтэй Зөвлөлийн Засагт Орос улсаас нэг түмэн гурван мянга таван зуун алтан төгрөгөөр тусламж болгон өгснөөс гадна шархадсан өвчтөнийг засан сувилахуй дор олон эмч нар явуулах явдал буй хэмээмой. (Олноо Өргөдсөний 13-р он) гэх зэргээр бичиж байв.

Тухайн үеийн тогтмол хэвлэлүүд дотор энэ талаар хамгийн их бичиж, Солонгосын ард түмний тусгаар тогтнолын төлөө тэмцэлийг сурталчилж байсан хэвлэл бол 1920 онд хэвлэгдэн гарч байсан “Монголын үнэн” хэмээх сонин болно. Тухайлбал: “Монголын үнэн” сонины 1920 оны 11-р сарын 1-ний өдрийн анхны дугаарт гарсан “Элдэв сонин” хэмээх буланд бичсэнээс үзвэл: “...тэр мэт Англид эзлэгдэн мөлжигдөгч Энэтхэг Жагарын ба Рибин (Япон)-д эзлэгдсэн Гуулин улс чөлөө эрхийг бадруулахуйяа туйлын хүчин гаргаж, тэдгээр эзэрхэг харгисуудын хатуу хөнөөлөөс гарахаар цөхрөлтгүй оролдож буй хэмээмүй” гэжээ.¹

“Монголын үнэн” сонины 3 дугаарт (1920 оны 11 дүгээр сар) “Солонгос улсын сонин” гэсэн мэдээ гарсныг үзвэл: “Америкийн мэдээгээр авахад, Солонгос улс нь, түүнийг түрэмгийлэн эзэлсэн Рибин лүгээ тэмцэх нь шинэ төлөвтэй боллоо. Рибин лүгээ байлдагч Солонгосын элссэн цэргүүд болбоос Солонгос улсын Бүгд найрамдах засгийг байгуулсан бөгөөд, түүний яамуудыг Рибиний тагнуулчин бэдэрч үл олмуй. Солонгос ард түмэн нь шинэ засгаа үнэнхүү манай өөрсдийн засаг хэмээн итгэж олонхи зон нь элдэв хэргүүдийг гагцхүү үндсэн яамандаа шийтгүүлэх болсноос Рибиний зарим Захирах, Шүүх таслах зэргийн яамууд сул орхигдсон хэмээмүй. Тиймийн тул Рибиний засгаас Солонгос улсын өөрийн эрмэлзэх хүсэл явдлыг гал мэсийн хүчээр няцуулан дарсугай хэмээн тогтов”² гэж бичсэнээс үзвэл, Японтой байлдаж байсан Солонгос цэргүүд өөрсдийн Бүгд Найрамдах Засгийг байгуулсныг нь Япончууд эрээд эрээд олохгүй байгаа тухай бичсэн байна.

“Монголын Үнэн” сонины 4-рт (1921 оны 3-р сарын 5-нд гарсан.) “Монгол улсын энэ цагийн байдал ба Ардын Намын бүтээх тус” хэмээх тэргүүн өгүүлэлд Японы зүгээс Зүүн Ази түүний дотор Тайвань, Солонгос, Хятадын Өмнөд Манж, Шаньдунд явуулж байсан харгис хэрцгий бодлогыг илчлэхийн хамт, Японтой ойртох бодлогогүй алхам хийж байсан тухайн үеийн зарим ноёдын үйл ажиллагаа хурцаар шүүмжлэн бичиж, гадаадын түрэмгийллээс анхааран болгоомжлохыг өгүүлэхдээ: “... Манай нүдэн үзтэл, Рибиний эзэрхэг түрэмгий засгийн цуст саварт атгагдан эзлэгдсэн 20 сая Солонгос улс 10 жилийн дотор хядагдахын туйлыг үзэж, амь биеэ алдаж, ард түмэн нь зүдрэн зовж байдаг.. Монгол улс, Рибиний харгисуудад эзлэгдвээс Хятадын харгисуудын дарамтаас зуун давхар хүчир хүнд боолчлогдох мөлжигдөх нь чухам болмуй. Юун

¹ “Монголын үнэн” сонин, Эмхэтгэн тайлбарласан Д.Даш, УБ 1971, 21-р тал.

² Мөн тэнд, 48-49-р тал.

хэмээвээс, Рибиний эзэрхэг түрэмгий нар нь эзэлсэн улс ба орны шим шүүсийг ховдог хорхой адил бүрмөсөн сорж, хөгжин босохын чадалгүйд хүртэл доройтуулах хэмээн дарладаг болой. Энэ учрын үнэнийг Солонгос мэтийн тэдэнд эзлэгдсэн улсаас лавтган мэдэгддэг буй” хэмээн нэн тодорхой бичсэн байна.³

Япончуудаас Солонгосын ард түмний талаар учруулж буй харгислалыг “Монголын үнэн” сонинд тухай бүр нь илчлэн, Солонгосын ард түмний тэмцлийг дэмжиж байжээ. Мөн дугаарт гарсан “Солонгос улсын тус” хэмээх өгүүлэлд: «...Энэ жил хаврын эхээр, Солонгос улс нэг мөсөн босоцгоож, Рибиний түрэмгий хүнд дарамтаас мултрахыг төхөөрснөөс тэр зорилгын нярай биежээгүй цагт нь няцуулах хэмээн Рибин засаг хүчилж баймуй. Солонгос улсын элссэн цэргүүдтэй Рибиний цэргүүд тулалдаж хэдэн удаа ялагдаад, догширч сургуулийн гэрүүд ба ер гэр балгадыг галдаж баймуй. Шоннинси хэмээх балгадад 18 гэр, 8 бага, 2 дунд зэргийн сургуулийн гэр, Ердагу хэмээх балгадад 21 гэрийг суусан хүмүүстэй нь шатаажээ. Гүнцүн мужид тариачдын гэрүүд олныг галдсанаас, тэнд тариачид орох гэр, идэх өмсөхөөс салснаар нэн их зовлон үзэж болай. Ийм хүчир их аюулаас ямар ч зэмгүй өвгөд ч зайлж эс чаджээ. Байчиу хэмээх оронд шашныг баригч нэгэн өвгөнийг зургаан хүмүүстэй чихний нүхэнд нь халуун төмөр саваагаар хатган алаад, тэдгээрийн үхээрийг аваачихаар ирсэн төрлийнх нь хүн нарыг бас хороов. Шигадун хэмээх мужид Рибинтэн нь нэг нүхэн дотор 14 хүнийг хөөн оруулаад тэдгээрийг дэнгийн тос цутган галдсан хэмээмүй. Энэ мэт Рибинтэн нь хүний дүрсгүй үйлдвэр (үйлдэл) хийж байна” гэж бичжээ.⁴

Тус сонин 5-р дугаарт нэгэн зургийн хуудас хэвлэсэн байдаг. Уг зургийн утга нь Япон нэг хөлөөрөө Солонгосыг, нөгөө хөлөөрөө Хятадыг шиншгэсэн байх ба нэг гартаа Семенов, нөгөө гартаа Унгерн гэж нэрлэсэн хоёр нохой барьсан байна. Үүнийг харж байгаа эх орноо сахин хамгаалж буй Орос Монгол хоёр цэрэг байна. 2 дахь зурагт Солонгос, Хятад, Монгол, Орос дөрвүүл нийлж мөнөөх Япон руу дайрч, далайд унаган живүүлж байгааг зуржээ. Зургийн тайлбарыг бичвэл:

“Манай сэтгүүлийн лүндэн. Мэхч Рибиний эзэрхэг түрэмгий нар Ази тивийн Солонгос, Хятад, Монгол зэргийн улсыг эзэлж боолчлох хэмээн зүтгэж буй. Түүнд дэлхий дахины дарлагдсан улс нарыг өмгөөлөгч улаан Орос улс саад хийж буйн тул өөрийн хөлчин зарц атаман Семенов, Барон Унгерн нарыг тухиран Орос улсыг довтлон дайтуулахаар баймуй. Чингэхдээ Рибин нь түүний ар дахнаас нь мөнхүү Азийг эзэрхэх саналтай Америк цохихоор бэлдэж байхыг үл мэдмүй. Үзвээс Рибиний шунахай хүчирхэг нар нь Ази тивийн тэмцлээр

³ Мөн тэнд, 54-р тал.

⁴ Мөн тэнд, 76-77-р тал

боссон олон улсуудын улаан Орос лугаа хавсарсан хамтын хүчээр цохигдон Шар далайд сандран унах цаг дөхөм болжээ.

Монгол авгай нараа, сэргэг сэрэмжтэй байгтун. Рибиний хүчирхэгүүд болон түүний зарц нарын худал хуурмаг үгэнд битгий хууртагтун. Солонгос, Хятад, Формоз (Тайвань.Ж.Б) ба Оросын Алс Дорнодын муждын дарлагдсан ард амьтны нулимс ба цус урсгасан муу үйлийнхээ үрийг тэдгээр шунахай харгисууд амсах цаг нь ойртов” гэжээ.

Энэ зургийн талаар тухайн үед Монгол улсад тагнан турших ажлаар очиж байсан хятад хүн болох Ма Хо Тиэнь өөрийн номондоо их л дэлгэрэнгүй өгүүлжээ. Түүнийг бичсэнийг үзвэл:

“... Миний сонирхлыг хувьсгалт зурагт хуудаснууд хадсан гоёмсог зурагтай авдарнууд ихэд татав. Тэдгээр нь Гадаад Монголын Ардын Намын Төв Хорооноос гаргасан өнгөт хэвлэлийн сурталчилгаа байлаа. Зурагт хуудас болгон хоёр фут өргөн, фут өндөртэй, хоёр хэсэгтэй аж. Нэгэн зурагт хуудасны баруун талын хэсэгт далай давуулан нэг хөлөө Хятад хүн дээр, нөгөө хөлөө Солонгос хүн дээр тавиад тавлан сагсууран зогсож буй бүдүүн тарган бөгөөд шүдээ арзайлгасан Японы араас нарны цацраг цацарч байгааг үзүүлжээ. Энэ нь зүүн далайд явуулсан Японы харгис түрэмгий үйл ажиллагаа, Солонгос дахь хөнөөлтэй ноёрхол, Хятад руу шунахайрч буйг илэрхийлжээ. Үүний хамт Америк хүн далайн дунд ажиглагч болон зогсож байна. Япон малгай өмссөн хэд хэдэн нохой Монгол хүн рүү амаа ангалзуулан архирч буйг мөн зуржээ. Монгол хүн айсан байдалтай холоос ажина. Улаан цэргийн өмсгөлтэй Орос буудахаар буу агсан зогсчээ. Энэ нь Япон улс цэрэг зэвсгийн хүчээр Монгол руу халдахаар зэхэж, Орос эсэргүүцэхэд нь туслахаар, АНУ анхааран харж буйг үзүүлжээ. Зурагт хуудасны зүүн хэсэгт Орос, Монгол, Солонгос, Хятад дөрөв Японыг далай руу буудан унагаж, Америк ч дээрээс нь буудаж байна. Энэхүү нэгдсэн довтолгоо цэргийн хувцас нөмөрсөн ноход руу ч мөн чиглэснийг дүрсэлжээ. Нэгдсэн хүчээр Японы империализмийг сөнөөхийг бэлгэдсэн энэ зурагт Орос, Монгол хоёр голд нь зогссон байна” хэмээн тайлбарлаад “энэхүү зурагт хуудаснаа Японыг эсэргүүцэх, Оростой ойртох, Хятад, Солонгостой хамтрах гэсэн Монголын гадаад бодлогыг хураангуйлан тодорхойлжээ” гэсэн сонирхолтой дүгнэлт өгчээ.⁵

“Монгол Үнэн” сонины 6-рт (1921 оны 4-р сарын 19-нд хэвлэгдсэн. Ж.Б) “Рибиний байдал ба Монгол хэрэг” хэмээх тэргүүн өгүүлэлдээ Барон Унгерн ба Японы бодлого, хэлхээ холбоо, ард түмнийг хууран мэхлээд дараа нь колоничлон дарладаг аргыг илчлэн шүүмжлэн бичсэн байна. Үүнд: “...Бас

⁵ Mo Ho Tien, “Chinese Agent in Mongolia”, Translated by John De Francis, Baltimore, The John Hopkins Press, 1949, pp.38-39.

Рибиний харгис хэрцгийг онод дарлагдсан Солонгос улс түүний дарлахад үл тэсэн, гадаад улсуудаас тэтгэмжийг олж, цэрэг байгуулан бүрэн зэвсэгт шаламгай эрсүүд Рибинийг дайлаар орж хэдэнтээ байлджээ... Тэр мэт Солонгос улс тусгаар болохыг чармайн атал, харин манай Монгол ямар санаагаар тэдний боол болох буй” гэж Солонгосоос жишээ татан бичжээ.⁶

“Монголын Үнэн” сонин 1920 оны 11-р сарын 10-наас 1921 оны 4-р сарын 18-ныг хүртэл нийт 6 дугаар гарчээ. 4 нүүртэй гарч байсан энэхүү сонинныг чулуун бараар, дугаар бүрийг 3000 хувь хэвлэж байв.

1915 оны 9-р сарын 11-нээс 1920 оны 1-р сарын 23-ны хооронд “Нийслэл Хүрээний сонин бичиг” гарч байсан⁷ бөгөөд энэ сонинд ч мөн Солонгосын тухай нийтэлж, монголчуудад танилцуулж байжээ. Жишээлбэл, тус сонинны 100 дахь дугаарын 3-р талд “Элдэв зүйлийн чимээ” хэмээх буланд “Нэгэн зүйл: Рибиний Засгийн газраас Солонгос нутгийг захирах сайдын тушаал дор гүнгийн зэрэг Саяатуа хэмээгчийг талбив. Мөнхүү сайд уг тушаал дор хүрч ирээд нутгийн суугчдад элдэв зүйлийн хэрэгт дарангуйлах зэрэг явдлыг хийлгэхгүй. Бас Солонгосын ардаас амин чадалтай хүмүүс гарах аваас элдэв зүйлийн албаны газрууд дор албан хийлгэхээс гадна нутгийн суугчид амар тайван сууваас, дунд байгуулах зэрэг захиргаа олж болмуй хэмээн зарласан боловч, Солонгос улс Рибиний сайдын мэдэл дор жаргалтай суух учирт арайхан (ер) итгэсэнгүй тул Нан Тай Мул хэмээх төмөр замын өртөөн дээр сайд Саяатуа-гийн явж байсан тэргэн дор аль нэгэн Солонгос хүмүүн бөмбөг хаясан боловч тэр бөмбөг дэлбэрээд сайд дор ум болгож чадсангүй амуй” гэхчилэн Солонгост болж байсан үйл явдлаас мэдээлж байв.⁸

Тухайн үед Монголын сурах бичгүүдэд ч Солонгосын тухай багагүй баримт нийтэлж байв. Эдгээр ном сурах бичгийн заримаас нь жишээ болгон өгүүлбэл, Эрдэнэбатхаан бичиж, 1928 онд Ардын Гэгээрүүлэх Яамнаас хэвлэсэн “Азиг тив” хэмээх номонд дэлхийн газрын зураг хэвлэсэн байдаг ба тэнд Солонгосын нийслэл Сөүл хотыг “Сиүл” гэж бичсэн байна. Солонгосын газарзүйн нэг томъёогоор “Солонгосын хагас арал” гэж бичжээ. Мөн номонд “Солонгосын тухай” гэсэн жижгэвтэр хэсэг байгаа бөгөөд тэнд: “Солонгос улс мөн хагас арал дор нутаглан суух бөгөөд, 1905 онд Орос Японы байлдаанаас хойш Япон улсын колони болжихуй. Нутгийн өмнө хагаст дулаан байх тул тутрага, умардад буудай таримуй. Солонгосын олонхи нь хэвийн номхон ядуу тариачин болох ба Хятад лугаа ойролцоо байдалтай хэмээвч Хятадаас баахан бүдүүлэг, бас тарианы үйлдвэр дор дутуу. Эртний цагт Дундад улс лугаа зузаан холбоотой явсан учир, Хятадын соёлыг авсан буй. Хүмүүн амын тоо арван найман сая.

⁶ “Монголын үнэн” сонин, 82-83-р тал.

⁷ Г.Дэлэг, Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл, УБ 1965.

⁸ УННС-ын “Тогтмол хэвлэлийн Архивийн фонд”

Урьдын нийслэл нь Снул хотон дор эдүгээ Солонгосыг захирах Японы сайд суумуй” гэжээ.⁹

“Дашням зохиов. Ардын гэгээрүүлэх яамнаас хэвлүүлэн нийтлэв. Монгол улсын 23-р он. Улаанбаатар хот” гэсэн зохиогч болон огноотой “Олон улсын дэлхийн байдал. Тус дэвтрийг думдад ба багш нарыг бэлтгэх сургуульд заамуй”¹⁰ гэсэн сурах бичигт Солонгосын тухай нэгэн бүлэг оржээ. Уг сурах бичигт “Гаоли буюу Солонгос эмэгтэй нум сум харваж байгаа зургийг тайлбарлаад уг зургийн дор “Японы империализм нь энэхүү ард түмний ашиг тусыг өчүүхэн ч харгалздаггүй бөгөөд, гагцхүү тэдгээрийн хүчийг ашиглахыг чухалчилмуй” гэж бичжээ.

“Гаоли” гэсэн нэрэн дор Солонгосын тухай дурдан тайлбарлажээ. Уг хэсэгт газарзүйн байдал, цаг уур, эдийн засгийн тухай бичихдээ:

“...Гаоли болвоос газар орны талаар их бөгөөд, Япон улсын нэгэн чухал колони нь болмуй . Энэхүү Гаоли орон нь Эквадороос хойш дөчдүгээр хөндлөн шугаман дээр оршин буй Азийн зүүн этгээдийн нэгэн хойг бөгөөд Япон улсын эх нутгаас нэгэн далайн хоолойгоор ангижирмуй. Тус хойгийн 10 хувь нь ой мод бөгөөд, төмрийн хүдэр, чулуун нүүрс зэргийн дэлхийн баялагтай баймуй. Цаг улирлын талаар Гаолийн хагас арал нь Японы эх нутгаас үлэмж сайн бөгөөд, дэлхийн баялгийн талаар Гаоли нь хэдүйвээр баялаг орон боловч түүнийг төдийлөн ашигласан үгүй учир нь колонийн газрын баялаг дотроос эзэн улсад үлэмжхэн ашигтай бөгөөд бага хүчин чадал хэрэглэгдэх зүйлсийг ашиглахаас бус колонийн орны аж үйлдвэрийн явдлыг дэлгэрүүлэхийг чухалчилдаг үгүй нь нийт эзэрхэг түрэмгий улсын ёс амуй. Тус орны хөдөө аж ахуйг сайжруулах тухай Японы империализмээс гүйцэтгэсэн ажил бага, гагцхүү өөрсдийн үйлдвэр дор чухал хэрэглэгдэх бүхүй хөвөнгийн ургацыг чухал болгон тарьж баймуй” гэсэн бол, цэрэг стратегийн үүднээс задлан шинжлэхдээ:

“...(Япончууд) гагцхүү цэргийн хүчийг зузаатгахын үүднээс тээх нэвтрүүлэх явдлыг сайжруулсан бөгөөд ерөөс Гаолийн хойг нь Хятад Манжуур ба Монгол хийгээд СССР-ийн Алс Дорнод зүгт цэргийн хүчээр довтолон орох төв дэвсгэр нь мөн болой” гэжээ. Зохиогч Солонгосын хүн амын талаар нэлээд тодорхой өгүүлж: “... Тус Гаолийн хойгийн бүх хүмүүн амын тоо 19 сая болохоос 2 хувь нь Японы хүмүүс болмуй. Хүмүүн амын олонхи болох тариачны байдал нь туйлын муу бөгөөд Японы эзэрхэг түрэмгийг эсэргүүцсэн эдний хөдөлгөөнийг Японы цагдаа цэргүүдээс маш хатуугаар дарангуйлан устгадаг амуй” хэмээн бичжээ. 1928 онд БНМАУ-ын Гадаад Явдлын яамнаас эрхлэн хэвлүүлсэн “Бүх дэлхийн улсын байдлыг товчилсон хоёрдугаар дэвтэр”-т “Солонгос (Чуу

⁹ МАХН-ын Архив. Х.Чойбалсангийн хувийн номын сан.

¹⁰ Х.Чойбалсангийн хувийн номын сан.

Сиян)-ын тухай. 1910 онд Япон Солонгос улсын түрэмгийлэн эзлэж өөрийн муж болгосон” гээд хүснэгтээр Солонгосын газар нутгийн хэмжээ хүн амын тоо, 1 хав. дөрвөлжин километрт хэдэн хүн оршин суудаг, үндэстний бүтэц, шашин, хотуудыг тодорхой гарган үзүүлжээ.

Үүнд: “Газрын хэмжээ: километр дөрвөлжинөөр 220701. Хүмүүн төрөлхтөн: Тоо 17, 280 сая. Дөрвөлжин километр газар дээр хэдэн хүн сууц буй. 78/1

Үндсэн	Солонгос Япон Хятад
Шашин	Тэн Шинэнтө Буддагийн ба Христосийн шашинтан

Хотууд ба онгоцуудын буудлах газар

Нийслэл хот Сөүл, Бин-Янь (Пён Ян), Бүүжэн (Пусан), Чимүллоо (Инчонь)” гэж бичсэн байна. 1943 онд Монгол Ардын Хувьсгалт Армийн улс төрийн Газраас “Нууц. Зөвхөн дарга нар хэрэглэнэ” гэсэн анхааруулгатай гарсан “Японы эзэрхэг түрэмгий нарын араатан шинжийн дүрс царай” гэсэн товхимолд Японы цэргийн төлөвлөгөө, байлдах довтлох арга, Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийг булаан эзлэх аян дайн явуулж ирсэн тухай нарийвчлан задлан шинжилсэн байна.¹¹ Уг товхимолд “Япон улс Солонгосын колони болгон хувиргасан нь” хэмээх нэгэн бөлөг байх бөгөөд тэнд бичсэннийг үзвэл “...Солонгосыг колончилсон түүх нь Япончуудаас Солонгосын ард түмнийг хамгийн зэрлэг харгисаар алан хядах ажиллагааг явуулсан жишээгээр дүүрэн болно. Япончуудын түрэмгий харгислал нь зах хязгааргүй олноор гянднаа хорих ба хоригдсон солонгосчуудыг тарчилган зовоож арьсыг нь хэсэг хэсгээр нь огтчих ба биенд нь хадаас шаах, шуудай саван дотор хийх зэргээр хамгийн хэрцгий муухай аргуудыг хэрэглэж байжээ. Америкийн дорнод зүгийн судлаач эрдэмтэн Мак-Кензигээс “Эрх чөлөөт Солонгосын төлөөнөө” хэмээх өөрийн дэвтрийн 253-р хуудсан дөр Сөүл Хотноо 1919 оны 3-р сард болсон эсэргүүцлийн сүрт жагсаалын тухай бичиж дурдсан нь: “Цагдаа нарын газрын хүмүүсээс Сөүлийн гудамжнаа нэгэн солонгосыг бариад мөн тэнд нь чихийг огтолж хуруунуудыг нь зүссэн ба түүний биенийг хатган нүхэлэнд хэдэн цаг болсны дараа өнөөх Солонгос нь үхэв гэжээ” хэмээн бичсэн байна. Энд өгүүлж буй 1919 оны 3-р сарын сүрт жагсаал гэдэг нь “Сам иль үн дун” буюу “Гурван сарын нэгний хөдөлгөөн” хэмээн түүхэнд алдаршсан тэмцэлт хөдөлгөөн, Японы колоний дарлалын эсрэг Солонгосын ард түмний хийсэн жагсаал бөгөөд олон мянган хүн оролцсон байна. Жагсаалд оролцогчдыг

¹¹ Х.Чойбалсангийн хувийн номын сан.

төлөөлсөн “Үндэсний төлөөлөгчид” болох гучин гурван хүн гарын үсгээ зурж ард түмнийхээ “Тусгаар Тогтнолын Тунхаглалыг” илэрхийлсэн бичгийг Японы амбан захирагчид гардуулсны харинуд япончууд үй оlnыг хамарсан харгислал явуулснаар олон мянган солонгос хүний амь насыг нь бүрэлгэж, шархдуулж, шорон гянданд цагдан хорьж, баривчилсан байдаг.

Ийнхүү Монголын ном хэвлэлд тухайн үед Солонгосын талаар нийтлэж байсан зүйлүүдийг тоймлон гаргавал голлон Японд эзлэгдэн дарлагдаж, харгислалд өртөн зовж буй Солонгосын ард түмний эрх чөлөөний тэмцлийг дэмжих, нөгөө талаас Японы колоничлолын бодлогыг шүүмжлэн буруушаасан агуулгатай байсан байна.